Инженерийн дэд бүтэц бүхий амины орон сууцны хэрэгцээтэй байгаа нийт өрхүүдийн **4,466** өрх нь буюу 21 хувь нь худалдан авах чадвартай гэж гарсан ба энэхүү тооцоллыг хийхэд тухайн өрхийн 1 сарын орлого нь 3 ба түүнээс дээш сая төгрөг байх, 3 ба түүнээс дээш эх үүсвэрээс орлого олдог байх, хуримтлалтай байх гэсэн шалгуур үзүүлэлтүүдийг авч үзсэн болно.

REAL ESTATE
REAL SOLUTIONS

15 ЖИЛ

ТЭНХЛЭГ ЗУУЧ
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ

# ОЙРЫН 3 ЖИЛИЙН ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЭЦ БҮХИЙ ТҮРЭЭСИЙН ОРОН СУУЦНЫ ЭРЭЛТ, ХЭРЭГЦЭЭ

# УЛААНБААТАР ХОТОД ИРЭХ 3 ЖИЛД ОРОН СУУЦ ТҮРЭЭСЛЭХ ХЭРЭГЦЭЭ



# УЛААНБААТАР ХОТОД ИРЭХ 3 ЖИЛД ОРОН СУУЦ ТҮРЭЭСЛЭХ ХЭРЭГЦЭЭ



**Түрээслэх хэрэгцээтэй**

**44,747 өрх**







Гэр хороололд амьдардаг өрхийн тоо /28,030/

Орон сууцанд амьдардаг өрхийн тоо /16,717/

# ОЙРЫН 3 ЖИЛИЙН ХУГАЦААНД ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЭЦ БҮХИЙ ОРОН СУУЦ ТҮРЭЭСЛЭХ ХЭРЭГЦЭЭТЭЙ ӨРХИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ

Инженерийн дэд бүтэц бүхий орон сууц түрээслэх хэрэгцээтэй байгаа нийт **44,747** өрх байна. Орон сууц түрээслэх сонирхолтой нийт өрхүүдийн 16,717 өрх нь нийтийн орон сууцанд, 14,686 өрх нь дэд бүтцэд холбогдоогүй хашаа байшинд, 13,016 өрх нь монгол гэрт, 329 өрх нь дэд бүтцэд холбогдсон хашаа байшин, АОС-нд амьдарч байна. Нийт түрээслэх хэрэгцээтэй байгаа өрхийн 10,364 өрх нь тухайн амьдарч буй суудаа түрээслэж амьдардаг бол 4890 өрх нь төлбөргүйгээр бусдын өмчлөлийн байранд төлбөргүйгээр амьдарч байна.



## УЛААНБААТАР ХОТОД ИРЭХ 3 ЖИЛД ОРОН СУУЦ ТҮРЭЭСЛЭХ ХЭРЭГЦЭЭТЭЙ ӨРХҮҮД, ЗОРИЛТОТ БҮЛГЭЭР

### АЛЬ НЭГ ЗОРИЛТОТ БҮЛЭГТ ХАМРАГДАЖ БАЙГАА ЭСЭХ







### ТҮРЭЭСЛЭХ ШАЛТГААН




Ирэх 3 жилийн хугацаанд инжнерийн дэд бүтэц бүхий орон сууц түрээслэх хүсэлтэй нийт 44,747 өрх байгаа юм. Үүнээс 28,5 хувь нь “гэр бүлийн бусад гишүүдийн хэрэгцээнд зориулж”, 28,1 хувь нь “өөрийн өмчлөлийн сууцгүй” гэсэн шалтгаанаар түрээслэх сонирхолтой байна. Харин эдгээр өрхүүдийн 33,9 хувь нь “залуу гэр бүл”, 23,2 хувь нь хувийн байгууллагын ажиллагсад болон хувиараа хөдөлмөр эрхлэгчид байна.

# ОРОН СУУЦ ТҮРЭЭСЛЭХ ХЭРЭГЦЭЭТЭЙ ӨРХҮҮДИЙН СОНИРХОЖ БУЙ БАЙРШИЛ



# ОЙРЫН 3 ЖИЛИЙН ХУГАЦААНД ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЭЦ БҮХИЙ ОРОН СУУЦ ТҮРЭЭСЛЭХ ХЭРЭГЦЭЭТЭЙ ӨРХ

## М2-ИЙН ХЭМЖЭЭ




## ӨРӨӨНИЙ ТОО




## ТҮРЭЭСЛЭХ ХУГАЦАА




## Түрээслэж байх явцдаа өөрийн эзэмшлийнх болгох сонирхол




Инженерийн дэд бүтэц бүхий орон сууц түрээслэх хүсэлтэй нийт өрхүүд дунджаар 31-50м2 талбаатай 2 өрөө байрыг, 4-5 жилийн хугацаатай түрээслэн өөрийн болгох сонирхолтой байна.

# ҮНЭ ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

ТЭНХЛЭГ ЗУУЧ
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ

## ТҮРЭЭСЛЭХ ӨРӨӨНИЙ СОНГОЛТ, БОЛОМЖИТ ҮНЭ

Инженерийн дэд бүтэц бүхий орон сууц түрээслэх хэрэгцээтэй нийт өрхийн хувьд 1 өрөө байрыг дунджаар 201,000-300,000 төгрөгөөр түрээслэх хүсэлтэй 5,761 өрх байгаа бол, 2 өрөө байрыг мөн адил үнээр түрээслэх хүсэлтэй байна. Харин 3 өрөө байрыг 401,000-500,000 төгрөгөөр түрээслэх хүсэлтэй 2,573 өрх байна.

| | 200,000₮ хүртэлх | 201,000-300,000₮ | 301,000-400,000₮ | 401,000-500,000₮ | 500,000₮ дээш |
|---|---|---|---|---|---|
| 1 өрөө | 5,542 | **5,761** | 2,861 | 630 | 630 |
| 2 өрөө | 5,657 | **14,471** | 5,825 | 4,841 | 2,353 |
| 3 өрөө | 226 | 630 | 685 | **2,573** | 1,297 |

## ТӨЛБӨР ТӨЛӨХ ХУВААРЬ



# ТҮРЭЭСЛЭХ БОЛОМЖТОЙ ҮНЭ, СОНГОЛТОНД НӨЛӨӨЛДӨГ ХҮЧИН ЗҮЙЛ

| Үзүүлэлтүүд | 1 өрөө | 2 өрөө | 3 өрөө |
|---|---|---|---|
| **Түрээслэх м2** | 34,7 | 48,3 | 65,4 |
| **1м2 талбайг түрээслэх үнэ** | 6,722₮ | 6,199 | 7,256 |
| **Нийт үнэ** | 233,250₮ | 299,410₮ | 474,545 |

1 өрөө 34,7м2 талбайтай байрыг 1м2-ийн үнийг 6,722 төгрөгөөр, нийт үнийн дүн 233,250 төгрөгөөр түрээслэх хэрэгцээтэй байна.
2 өрөө 48,3м2 талбайтай байрыг 1м2-ийн үнийг 6,199 төгрөгөөр, нийт үнийн дүн 299,410 төгрөг,
3 өрөө байрыг 65,4м2 талбайг 1м2-ийн үнийг 7,256 төгрөгөөр нийт үнийн дүн 474,545 төгрөг байхаар сонирхож байна.



# ОРОН СУУЦ ТҮРЭЭСЛЭХ ХЭРЭГЦЭЭТЭЙ ӨРХҮҮДИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

## АМ БҮЛИЙН ТОО

**4.4** Дундаж ам бүлийн тоо

**2.1** 0-17 насны хүүхэдтэй

## ӨРХИЙН ТЭРГҮҮНИЙ ДУНДАЖ НАС

**43.3**

Орон сууц түрээслэхээр сонирхож буй нийт өрхүүдийн, өрхийн тэргүүний дундаж нас 43,3 байна.

## ЦАЛИН ХӨЛСТЭЙ АЖИЛ ЭРХЭЛДЭГ ХҮНИЙ ТОО

**1.6**

Өрхийн нийт цалин хөлстэй ажил эрхэлдэг гишүүдийн тоо 1,6 байгаа бөгөөд энэ нь

## ӨРХИЙН ТЭРГҮҮНИЙ АЖИЛ ЭРХЛЭЛТ



# ӨРХИЙН САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

ТЭНХЛЭГ ЗУУЧ
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ
15 ЖИЛ

**БАГА ОРЛОГОТОЙ ӨРХИЙН ТОО**

/Өрхийн сарын дундаж орлого 1 сая болон түүнээс доош/

**35,983**
**/69,5%/**

**ДУНДАЖ ОРЛОГОТОЙ ӨРХИЙН ТОО**

/Өрхийн сарын дундаж орлого 1-4 сая төгрөг хүртэлх/

**13,738**
**/26,5%/**

**ДУНДЖААС ДЭЭГҮҮР ОРЛОГОТОЙ ӨРХИЙН ТОО**

/Өрхийн сарын дундаж орлого 4 сая болон түүнээс дээш/

**2,046**
**/3,9%/**

---

Инженерийн дэд бүтэц бүхий орон сууц түрээслэх хэрэгцээтэй нийт өрхийн 35,983 өрх нь бага орлоготой буюу өрхийн 1 сарын дундаж орлого нь 1 сая төгрөг буюу түүнээс доош байгаа бол, дундаж орлогой 13,738 өрх байгаа байна. Харин дундаас дээгүүр буюу 4 сая төгрөгнөөс дээш орлоготой 2,046 өрх түрээсийн орон сууцыг сонирхож байна.

**20,740**
**/40%/**
**ЗЭЭЛТЭЙ ӨРХ**



# УЛААНБААТАР ХОТОД ОДОО ОРОН СУУЦ ТҮРЭЭСЛЭН АМЬДАРДАГ ӨРХҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ /31,402 өрх/

| ӨРХИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ | ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТ |
|---|---|
| Нийт ам бүлийн тоо | **3,5** |
| 0-17 нас хүртэлх хүүхдийн тоо | **1,8** |
| Гэр бүлийн ажил эрхэлдэг гишүүдийн тоо | **1,4** |
| Гадаад ажиллаж буй гишүүн байгаа эсэх | **6,6%** |
| Өрхийн тэргүүний дундаж нас | **36** |
| **СУУЦНЫ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ** | **ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТ** |
| Сууны талбайн хэмжээ | **49,4** |
| 1 сууцанд амьдарч буй өрхийн тоо | **1** |
| Дундаж цалин | **901,740₮** |
| Хуримтлал байгаа эсэх | **21,1%** |

| ТҮРЭЭСЛЭЖ БУЙ ӨРХҮҮД /ДҮҮРГЭЭР/ | ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТ |
|---|---|
| Сонгинохайрхан | **10,382 өрх** |
| Баянзүрх | **9,004 өрх** |
| Хан-Уул | **4,217 өрх** |
| Баянгол | **4,101 өрх** |
| Чингэлтэй | **2,435 өрх** |
| Сүхбаатар | **454 өрх** |
| Налайх | **280 өрх** |
| Багануур | **459 өрх** |
| Багахангай | **70 өрх** |
| **НИЙТ ӨРХИЙН ТОО** | **31,402** |

# УЛААНБААТАР ХОТОД ОДОО ОРОН СУУЦ ТҮРЭЭСЛЭН АМЬДАРДАГ ӨРХҮҮДИЙН ХЭРЭГЦЭЭ /31,402 өрх/

Улаанбаатар хотод түрээсийн орон сууцанд амьдардаг нийт 31,402 өрх байгаа бөгөөд эдгээр өрхийн дийлэнх хэсэг нь Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт амьдарч байна. Инженерийн дэд бүтэц бүхий орон сууц түрээслэн амьдардаг нийт өрхийн хувьд 1-рт инженерийн дэд бүтэц бүхий орон сууц худалдаж авах, 2-рт түрээсийн орон сууц хөтөлбөрт хамрагдан орон сууц түрээслэх, 3-рт хувийн сууц барих сонирхолтой байна.



REAL ESTATE
REAL SOLUTIONS

15 ЖИЛ

ТЭНХЛЭГ ЗУУЧ
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ

# ОЙРЫН 3 ЖИЛИЙН ХУГАЦААНД ӨӨРИЙН ГАЗАР ДЭЭРЭЭ ДЭД БҮТЭЦ БҮХИЙ ХУВИЙН СУУЦ БАРИХ ЭРЭЛТ, ХЭРЭГЦЭЭ

# УЛААНБААТАР ХОТОД ИРЭХ 3 ЖИЛД ДЭД БҮТЭЦ БҮХИЙ АМИНЫ ОРОН СУУЦ БАРИХ ХЭРЭГЦЭЭ



# УЛААНБААТАР ХОТЫН ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЭЦ БҮХИЙ ХУВИЙН СУУЦ БАРИХ ӨРХҮҮДИЙН ИРЭХ 3 ЖИЛИЙН ЭРЭЛТ ХЭРЭГЦЭЭ

**ХЭРЭГЦЭЭТЭЙ**
**73,336**
**ӨРХ**




**Гэр хороололд амьдардаг өрхийн тоо**
**57,473**

**Орон сууцанд амьдардаг өрхийн тоо**
**15,863**

# ХУВИЙН СУУЦ БАРИХ ХЭРЭГЦЭЭТЭЙ ӨРХИЙН ОДООГИЙН СУУЦНЫ НӨХӨЛ

ТЭНХЛЭГ ЗУУЧ
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ
15 ЖИЛ

Улаанбаатар хотын хэмжээнд нийт **73,336** өрхөд шинээр хувийн сууц барин амьдрах эрэлт хэрэгцээ байгаа бөгөөд энэхүү хэрэгцээтэй өрхийн 40 хувь нь гэр хороололд монгол гэрт амьдарч байна. Харин дараагаар нь уламжлалт аргаар барьсан дэд бүтцэд холбогдоогүй хашаа байшинд амьдарч байгаа 25,391 өрхөд шинээр сууц барих хэрэгцээ шаардлага байна.



**ХЭРЭГЦЭЭТЭЙ БАЙГАА**

**73,336 ӨРХ**

| | | |
|---|---|---|
| МОНГОЛ ГЭР | 40,0% | 29,381 ӨРХ |
| ДЭД БҮТЦЭД ХОЛБОГДООГҮЙ ХАШАА БАЙШИН | 29,8% | 25,391 ӨРХ |
| НИЙТИЙН ОРОН СУУЦ | 26,7% | 15,863 ӨРХ |
| ДЭД БҮТЦЭД ХОЛБОГДСОН ХАШАА БАЙШИН, АОС | 3,5% | 2,701 ӨРХ |

# ШИНЭЭР СУУЦ БАРИХ ЗОРИЛГО, ТӨЛӨВЛӨЛТ

## СУУЦ БАРИХ ЗОРИЛГО




## СУУЦ БАРИХ ОН




## ХУВИЙН СУУЦНЫ ДЭД БҮТЭЦ




Ирэх 3 жилийн хугацаанд хувийн сууж барих хэрэгцээтэй нийт өрхийн 40 хувь буюу 41,570 өрх нь 2020 онд болон түүнээс цааш барих төлөвлөгөөтэй байна. Энэхүү барих сууцаа нийт өрхийн 60 хувь нь төвлөрсөн шугам сүлжээнд холбох сонирхолтой байгаа бөгөөд, дийлэнх өрх буюу нийт өрхийн 36,3 хувь нь өрхийн орон сууцны нөхцөлөө сайжруулах хүсэлтэйгээр барих хэрэгцээтэй байна.

# ХУВИЙН СУУЦ БАРИХ БАЙРШИЛ



# ХУВИЙН СУУЦ БАРИХ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨЛТ

ТЭНХЛЭГ ЗУУЧ
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ

## Өрхийн хэд дэх ҮХХ болох эсэх




## Сууцны дундаж талбайн хэмжээ

**73,6 м2**

## Нийт үнийн дүн

**50,675,749 ₮**

## Өрөөний тоо

**3&4 өрөө**

## ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР




Хувийн сууц барих хэрэгцээтэй байгаа нийт өрхийн 36 хувь нь 100 хувь өөрсдийн эх үүсвэрээр, 28,8 хувь нь арилжааны банкнаас зээл авч сууцаа барих бол, дунджаар 73,6 м2 талбайтай 3 болон 4 өрөө байрыг нийт үнийн дүн 50,675,749 төгрөгөөр барихаар төлөвлөж байна.

# ӨРХИЙН САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

**БАГА ОРЛОГОТОЙ ӨРХИЙН ТОО**

/Өрхийн сарын дундаж орлого 1 сая болон түүнээс доош/

**45,707**
**/67,5%/**

**ДУНДАЖ ОРЛОГОТОЙ ӨРХИЙН ТОО**

/Өрхийн сарын дундаж орлого 1-3 сая төгрөг хүртэлх/

**24,333**
**/28,3%/**

**ДУНДЖААС ДЭЭГҮҮР ОРЛОГОТОЙ ӨРХИЙН ТОО**

/Өрхийн сарын дундаж орлого 3 сая болон түүнээс дээш/

**3,296**
**/4,2%/**

---

Шинээр өрхийн хэрэгцээнд зориулан сууц барих хүсэлтэй байгаа нийт өрхийн 67,5 хувь буюу 69,720 бага орлоготой өрх байна. Нийт 44,608 өрх нь ямар нэгэн байдлаар зээлтэй ба, нийт зээлийн 48,6 хувийг цалингийн зээл эзэлж байна.

**32,636**
**/45%/**
**ЗЭЭЛТЭЙ ӨРХ**



REAL ESTATE
REAL SOLUTIONS

15 ЖИЛ

ТЭНХЛЭГ ЗУУЧ
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ

# ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮДЭД ХАНДАХ ХАНДЛАГА

## Ирэх 3 жилийн хугацаанд өөрсдийн эзэмшлийн хашаанд дэд бүтэц шийдэж, шугам сүлжээг оруулж ирвэл амьдрах сууцаа өөрчлөх эсэх




- ✓ Орон сууцанд орно
- ✓ Газраа чөлөөлж орон сууц болгох сонирхолтой
- ✓ Баталгаагүй

**Эх үүсвэр**




**98,633 өрх**

**/28,7%/**

Өөрсдийн эзэмшлийн газартай

# ГЭР ХОРООЛЛЫН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТ, ГАЗРЫГ УРЬДЧИЛГАА ТӨЛБӨРТ ТООЦУУЛАХ

Таны ээшлийн хашаа Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөлд хамрагдах тохиолдолд та газраа орон сууцаар солих уу?




1м2

**Солих дундаж талбай**

**60,8м2**

- ✓ Дэд бүтцэд холбогдон амьдрах сонирхолтой
- ✓ Төсөл хэрэгжих гэж уддаг
- ✓ Газрыг маш багаар үнэлдэг
- ✓ Орон сууцаа чанаргүй барьдаг

# ГАЗРЫГ УРЬДЧИЛГАА ТӨЛБӨРТ ТООЦУУЛАХ



REAL ESTATE
REAL SOLUTIONS

15 ЖИЛ

ТЭНХЛЭГ ЗУУЧ
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ

# ӨРХИЙН ПРОФАЙЛ, ОРЛОГО, ЗАРЛАГА

# НИЙТ ӨРХИЙН ПРОФАЙЛ

ТЭНХЛЭГ ЗУУЧ
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ
15 ЖИЛ

## Хүйсийн харьцаа

**80%** Эрэгтэй

**20%** Эмэгтэй

## Гэрлэлтийн байдал

| | |
|---|---|
| **Гэрлэсэн** | **77.9%** |
| **Салсан, бэлэвсэн** | **2.6%** |
| **Гэрлээгүй** | **6.5%** |
| **Хариулахаас татгалзсан** | **3.0%** |

## Ам бүл

**4.2**

## Боловсрол






# НИЙТ ӨРХИЙН ПРОФАЙЛ /АЖИЛ ЭРХЛЭЛТ/

**Гэр бүлийн цалин хөлстэй ажил эрхэлдэг гишүүдийн тоо**




**Гадаадад ажиллаж байгаа гишүүн байгаа эсэх**

**Тийм-5,9%**
**Үгүй-94,1%**






# УЛААНБААТАР ХОТЫН ӨРХҮҮДИЙН 1 САРЫН ДУНДАЖ ОРЛОГО

ТЭНХЛЭГ ЗУУЧ
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ
15 ЖИЛ

Улаанбаатар хотын 1 өрхийн, 1 сарын дундаж орлого нь 2017 оны байдлаар 1,188,933 төгрөг байгаа бөгөөд энэхүү орлогын 717,687 төгрөг нь тухайн өрхийн гишүүдийн сарын цалин байна. 2014 онд 1 өрхийн, 1 сарын дундаж орлого 1,249,876 төгрөг байсан бол 2017 онд 1,188,933 болж 4,8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.




*Эх сурвалж: Статистикийн хороо 1212.Mn*

# УЛААНБААТАР ХОТЫН ӨРХҮҮДИЙН 1 САРЫН ДУНДАЖ ЗАРЛАГА

1 өрхийн сарын дундаж орлого 2017 оны байдлаар 1,188,933 төгрөг байгаа бол дундаж зарлага нь 1,188,837 төгрөг байна. Харин энэхүү зарлагын 96 хувь буюу 1,136,500 төгрөг нь мөнгөн зарлага болдог байна.




*Эх сурвалж: Статистикийн хороо 1212.Mn*

# НИЙТ СУДАЛГААНД ХАМРАГДСАН ӨРХИЙН ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ



# НИЙТ СУДАЛГААНД ХАМРАГДСАН ӨРХИЙН ХУРИМТЛАЛ

Нийт хэрэгцээтэй байгаа өрхийн 21,5 хувь буюу 72,423 өрх нь тодорхой хэмжээгээр хуримтлалтай ба энэхүү хуримтлалын 6,2 хувийг 1 сая төгрөг хүртэлх хуриммтлал эзэлж байна. Харин нийт өрхийн 73 хувь нь их бага хэмжээгээр ямар ч хуримтлал байхгүй ба, 5,5 хувь нь хуримтлал байгаа эсэхээ хэлэхээс татгалзсан байна.



# ТАХ-ын ОРОН СУУЦНЫ ЭРЭЛТ

# ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ТОО /УЛСЫН ХЭМЖЭЭНД/

ТЭНХЛЭГ ЗУУЧ
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ
15 ЖИЛ

**УЛААНБААТАР ХОТ**
**94,977**

**+**

**21 АЙМАГ**
**97,498**

**=**

**НИЙТ**
**192,475**

Улсын хэмжээнд 2017 оны байдлаар нийт 192,475 төрийн албан хаагч ажиллаж байна. Нийт төрийн албан хаагчийн 49,3 хувийг Улаанбаатар хотын төрийн албан хаагчид эзэлж байна.




*Эх сурвалж: Статистикийн хороо 1212.Mn*

# ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ТОО /УЛСЫН ХЭМЖЭЭНД/

**НИЙТ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ТОО 192,475**

- **МЭДЭЛЭЛ НЬ НЭЭЛТТЭЙ 138,652**
  - **ХУВИЙН ӨМЧИЙН СУУЦТАЙ 127,585**
    - **ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЭЦ БҮХИЙ СУУЦТАЙ 85,976**
  - **ХУВИЙН ӨМЧИЙН СУУЦГҮЙ 11,068**
    - **ТҮРЭЭСИЙН СУУЦ 5,442**
    - **БУСДЫН СУУЦ 5,626**
- **МЭДЭЭЛЭЛ НЬ ХААЛТТАЙ 53,823**

*Энэхүү тайланд тусгай чиг үүргийн байгууллагын албан хаагчдын мэдээлэл ороогүй бөгөөд энэхүү төрийн албан хаагчдын мэдээллийг нууцалдаг тул бусад байгууллагын төрийн албан хаагчдын мэдээлэл орсон болно.*

*Эх сурвалж: Төрийн албаны зөвлөл*

# ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ОДООГИЙН СУУЦНЫ МЭДЭЭЛЭЛ






Улсын хэмжээнд 2017 оны байдлаар нийт 192,475 төрийн албан хаагч ажиллаж байна. Нийт төрийн албан хаагчийн 49,3 хувийг Улаанбаатар хотын төрийн албан хаагчид эзэлж байна.

127,585 төрийн албан хаагч нь өөрийн эзэмшлийн сууцтай бөгөөд, 5,442 төрийн албан хаагч нь бусдын өмчлөлийн сууцанд түрээсээр амьдардаг бол 5,626 төрийн албан хаагч нь бусдын өмчлөлийн сууцанд төлбөргүйгээр амьдарч байна.

*Эх сурвалж: Төрийн албаны зөвлөл*

# ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ОДООГИЙН СУУЦНЫ МЭДЭЭЛЭЛ /ӨӨРИЙН ЭЗЭМШЛИЙН/







Өөрийн эзэмшлий сууцтай нийт 127,585 төрийн албан хаагч байгаа бөгөөд 59,3 хувь буюу 75,709 төрийн албан хаагч нь инженерийн дэд бүтэц бүхий орон сууцанд амьдарч байна. Дараагаар нь гэр хороололд монгол гэрт 20,689 төрийн албан хаагч амьдарч байна.

*Эх сурвалж: Төрийн албаны зөвлөл*

# ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ӨӨРИЙН ЭЗЭМШЛИЙН ОДООГИЙН СУУЦНЫ МЭДЭЭЛЭЛ /БАЙГУУЛЛАГЫН ТӨРЛӨӨР/

ТЭНХЛЭГ ЗУУЧ
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ

Өөрийн эзэмшлийн сууцтай 127,585 төрийн албан хаагч байгаа бөгөөд эдгээрээс боловсролын салбарт ажиллаж буй 62,666 төрийн албан хаагчид байна. Дараагаар нь эрүүл мэндийн салбарт ажиллаж буй 20,401 төрийн албан хаагчид орж байна.






*Эх сурвалж: Төрийн албаны зөвлөл*

# ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ОДООГИЙН СУУЦНЫ МЭДЭЭЛЭЛ /БУСДЫН СУУЦ, ТҮРЭЭСТЭЙ/







Сууц түрээслэн амьдардаг нийт төрийн албан хаагдын 60 хувь буюу 3,272 албан хаагч нь инженерийн дэд бүтэц бүхий орон сууцыг түрээслэж байгаа бол дараагаар нь 590 төрийн албан хаагч нийтийн зориулалттай байр түрээслэж байна. Сууц түрээслэж байгаа нийт төрийн албан хаагчдыг насны бүлгээр ангилж үзвэл 26-35 насны залуучууд 45 хувийг эзэлж байна.

*Эх сурвалж: Төрийн албаны зөвлөл*

# ТӨРИЙН АЛБАН ХААГЧДИЙН ТҮРЭЭСЛЭЖ БУЙ ОДООГИЙН СУУЦНЫ МЭДЭЭЛЭЛ /БАЙГУУЛЛАГЫН ТӨРЛӨӨР/

Улсын хэмжээнд сууц түрээслэн амьдарч байгаа нийт 5,442 төрийн албан хаагч байгаа бөгөөд эдгээр төрийн албан хаагчдийн 2,990 албан хаагч нь боловсролын салбарт ажиллаж байна.




*Эх сурвалж: Төрийн албаны зөвлөл*

# ӨРХИЙН ОДООГИЙН ОРОН БАЙРНЫ НӨХЦӨЛ, АМЬДАРЧ БУЙ БАЙРШИЛ - ТАХ

Монгол улсын хэмжээнд нийт төрийн албан хаагчдын 46.3% нь буюу 89118 төрийн албан хаагч ямар нэгэн байдлаар нийтийн орон сууцанд аж төрж байна. 39.6% буюу 76322 албан хаагч дэд бүтцэд холбогдоогүй хашаа байшинд, 12.2% буюу 23490 өрх Монгол гэрт амьдарч байна. Дэд бүтцэд холбогдсон байшингийн дундаж талбайн хэмжээ бусад төрлийн сууцтай харьцуулахад харьцангүй өндөр уюу 57 м.кв байна. Харин Орон сууцанд амьдарч буй төрийн албан хаагчдын гэр бүлийн 51% нь 2 өрөө сууц, 28% нь 1 өрөө сууц юм.

| Нийтийн орон сууц | Хаус-АОС | Дэд бүтцэд холбогдсон хашаа байшин | Дэд бүтцэд холбогдоогүй хашаа байшин | Монгол гэр |
|---|---|---|---|---|
| **46.3%** | **0.1%** | **1.7%** | **39.6%** | **12.2%** |
| 89118 албан хаагч | 270 албан хаагч | 3275 албан хаагч | 76322 албан хаагч | 23490 албан хаагч |
| 1 сууцанд **1.6** өрх | 1 сууцанд **2.8** өрх | 1 сууцанд **1.4** өрх | 1 сууцанд **1.3** өрх | 1 сууцанд **1.2** өрх |
| Сууцны талбай **43.1** м2 | Сууцны талбай **57.5** м2 | Сууцны талбай **63.9** м2 | Сууцны талбай **55.6** м2 | |

## ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУУЦНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ

**ОРОН СУУЦ ХУДАЛДАЖ АВАХ ХЭРЭГЦЭЭТЭЙ НИЙТ**
**56,467 ТАХ**

**ЯМАР Ч ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ БАЙХГҮЙ**
**14,306 ТАХ**

**ЯМАР НЭГЭН ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨТЭЙ**
**42,161 ТАХ**

# ӨРХИЙН ОДООГИЙН ОРОН БАЙРНЫ НӨХЦӨЛ, АМЬДАРЧ БУЙ БАЙРШИЛ - ТАХ

ТЭНХЛЭГ ЗУУЧ
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ
15 ЖИЛ

## *** СУУЦНЫ ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР ***

Орон сууцанд амьдарч буй төрийн албан хаагчдын 38% буюу 34473 төрийн албан хаагч тухайн орон сууц нь хувийн эзэмшлийн хэдий ч сууц барьцаалсан ямар нэгэн зээлтэй амьдарч байна. Үүнээс гадна 33% буюу 30181 албан хаагч одоо амьдарч буй орон сууцаа түрээслэж амьдардаг байна. Орон сууцанд амьдарч буй өрхийн 21% */4856 АХ/* буюу 5 өрх тутмын 1 нь өөрийн эзэмшлийн сууцандаа орон сууц барьцаалсан ямар нэгэн зээлгүйгээр амьдарч байна.



# ӨРХИЙН ОДООГИЙН ОРОН БАЙРНЫ НӨХЦӨЛ, АМЬДАРЧ БУЙ БАЙРШИЛ - ТАХ

## *** ГАЗРЫН ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР, ХЭМЖЭЭ***

Нийтийн орон сууцнаас бусад төрлийн сууцанд амьдарч буй өрхүүдийн одоо амьдарч буй газрын дундаж хэмжээ 630 орчим м.кв байна. Нийт 71% нь газар өмчлөлийн гэрчилгээтэй бол 86 хувь нь хувийн өмчийн газар дээрээ амьдарч байна. 11% нь төлбөргүйгээр бусдын эзэмшлийн газар дээр амьдарч байгаа байна.

Төрийн албан хаагчдын **51.6%** 99,812 төрийн албан хаагч дэд бүтэцгүй орон сууц буюу гэр хороололд амьдарч байна.

Одоо амьдарч буй газрын дундаж хэмжээ: **634 м2**

Одоо амьдарч буй газрын өмчлөлийн хэлбэр:




Одоо амьдарч буй газрын эзэмшлийн хэлбэр:



# НИЙТ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ОРОН СУУЦ ХУДАЛДАЖ АВАХ ХЭРЭГЦЭЭ /САЛБАРААР/




Онцгой байдал болон цэрэг, цагдаагийн албан хаагчид орсон болно

# ОРОН СУУЦ ХУДАЛДАН АВАХ ЭРЭЛТТЭЙ НИЙТ ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ХУДАЛДАН АВАХ ЧАДВАРААР БАТАЛГААЖСАН ЭРЭЛТ /ИПОТЕКИЙН ЗЭЭЛ/

Урьдчилгаа 30 болон түүнээс дээш хувь төлөх боломжтой нийт өрхийн тоо; **33,201 өрх**

Өрхийн татварын өмнөх орлогын 45 хувь нь зээлийн сар бүрийн төлбөрийг төлж хүрэлцэхүйц байх; **27,817 өрх**

Худалдан авах нийт талбайн хэмжээ 80м2-аас хэтрэхгүй байх; **56,467 өрх**

| Худалдан авах чадвараар баталгаажсан нийт өрхийн тоо | УБ хот | Орон нутаг |
|---|---|---|
| 2018 онд | 2,278 | 928 |
| 2019 онд | 2,892 | 1,012 |
| 2020 онд | 2,960 | 1,125 |
| 2021 онд | 1,985 | 466 |
| 2022 он болон түүнээс цааш | 363 | 1351 |
| **Нийт** | **10,478** | **4,882** |

**15,360**

Ипотекийн зээлээр орон сууц худалдан авах хэрэгцээтэй нийт төрийн албан хаагчдын ирэх 5 жилийн худалдан авах чадвараар баталгаажсан эрэлт 15,360 төрийн албан хаагч байна.

# БЭЛЭН МӨНГӨӨР ХУДАЛДАЖ АВАХ ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ ӨРХҮҮДИЙН ХУДАЛДАН АВАХ ЧАДВАРААР БАТАЛГААЖСАН ЭРЭЛТ

Инженерийн дэд бүтэц бүхий орон сууц худалдан авах хэрэгцээтэй нийт 5,647 төрийн албан хаагчаас худалдан авах чадвараар баталгаажсан 19,201 байгаа бөгөөд эдгээр төрийн албан хаагчийн 1,920 ирэх 5 жилд бэлэн мөнгөөр худалдан авах төлөвлөгөөтэй байгаа бөгөөд эдгээр албан хаагчдыг өрхийн орлого, орлогын эх үүсвэрийн тоо, өрхийн хуримтлал зэрэг тодорхой үзүүлэлтүүдээр шүүлтүүр хийж үзэхэд 11 хувь буюу 1,920 төрийн албан хаагч нь орон сууц худалдаж авах чадвартай гэсэн үр дүн гарсан.

**1,920 өрх**
Худалдан авах чадвартай



# ХУДАЛДАН АВАХ ЧАДВАРААР БАТАЛГААЖСАН ОРОН СУУЦНЫ ЭРЭЛТ - ТАХ

ТЭНХЛЭГ ЗУУЧ
үл хөдлөх хөрөнгийн компани

## *** ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ОРОН СУУЦНЫ ХЭРЭГЦЭЭ БАЙРШЛААР***




**17,280 өрх**
Худалдан авах чадвартай

| Байршил | Тоо хэмжээ |
|---|---|
| Баянзүрх дүүрэг | 1,728 |
| Хан-Уул дүүрэг | 1,920 |
| Баянгол дүүрэг | 1,993 |
| Сүхбаатар дүүрэг | 2,112 |
| Чингэлтэй дүүрэг | 960 |
| Сонгинохайрхан дүүрэг | 961 |
| Налайх дүүрэг | 768 |
| Багануур | 576 |
| Багахангай | 576 |
| | **11,594** |

- **Одоо амьдарч буй аймгийн төвд –4,980 АХ** */34.3%/*
- **Өөр аймгийн төвд – 538 АХ** /2.8%/
- **Одоо амьдарч буй аймгийн аль нэг суманд – 168 АХ** */0.9%/*

**5,686**

- Төрийн албан хаагчдын хамгийн их сонирхож байгаа дүүрэг БГД байна. Худалдан авах чадвартай албан хаагчдын 1,993 албан хаагч энэ байршилд орон сууц авах сонирхолтой байна.
- Харин орон нутгийн албан хаагчдын хувьд тухайн орон нутгийнхаа төв хотод орон сууц худалдан авах онирхолтой байна.

# ХУДАЛДАН АВАХ ЧАДВАРААР БАТАЛГААЖСАН ОРОН СУУЦНЫ ЭРЭЛТ - ТАХ

ТЭНХЛЭГ ЗУУЧ
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ
15 ЖИЛ

## *** ХУДАЛДАН АВАХ ЧАДВАРТАЙ ӨРХИЙН ОРОН СУУЦ ХУДАЛДАН АВАХ ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ***

- Шалгуур үзүүлэлтүүдийг хангасан орон сууц худалдан авах эрэлттэй болон худалдан авах чадвартай нийт **17,280** төрийн албан хаагч байна. Эдгээр албан хаагчдын 88% нь буюу **15,360** албан хаагчид нь ипотекийн зээлийн нөхцлийг хангаж чадахуйц байна.
- 965 албан хаагч газраа чөлөөлөн байраар солих хүсэлтэй байгаа бөгөөд эдгээр албан хаагчдын 23.5 хувь нь буюу дийлэнх хувь нь СХД-д амьдарч байна.

Хуучин орон сууцаа зарж борлуулах солих
*/**956** АХ/*

| Үзүүлэлтүүд | Дундаж үзүүлэлт | УБ хот өрхийн тоо | Орон нутаг өрхийн тоо |
|---|---|---|---|
| Сууцны төрөл | Орон сууц | 123 | 82 |
| Эзэмшлийн хэлбэр | Хувийн өмч | 99 | 121 |
| Дундаж талбайн хэмжээ | 54,7 | 87 | 63 |
| Өрөөний тоо | 2 болон 3 | 145 | 93 |
| Борлуулах нийт үнэ | 73,216,145₮ | 73 | 70 |
| НИЙТ | | 527 | 429 |

Газраа чөлөөлөн байраар солих хүсэлтэй байгаа /**965**/ өрхүүдийн одоогийн байршил



# ХУДАЛДАН АВАХ ЧАДВАРААР БАТАЛГААЖСАН ОРОН СУУЦНЫ ЭРЭЛТ - ТАХ

## *** ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ХУДАЛДАЖ АВАХ ОРОН СУУЦНЫ ТӨРӨЛ, ШААРДЛАГА***

- Орон сууц худалдан авах албан хаагчдын хувьд дунджаар 64.8 м.кв талбайтай орон сууц худалдан авах сонирхолтой байна. Нарийвчилсан үр дүнг харахад 40% нь 61-80 хүртэлх м.кв талбайтай орон сууц, 44% нь 41-60 м.кв талбайтай орон сууц сонирхож байна.
- Мөн 74% нь бүрэн цутгамал орон сууц, 58% нь 2 өрөө орон сууц хамгийн нийтлэг сонирхож буй орон сууц байна.

Худалдан авахаар сонирхож байгаа орон сууцны талбайн дундаж хэмжээ **64.8** м.кв




БАРИЛГЫН ХИЙЦ







СУУЦНЫ ТӨРӨЛ

| ТӨРӨЛ | ХУВЬ |
|---|---|
| Хүн амьдарч байгаагүй цоо шинэ сууц | 75% |
| Хуучин болон шинэ аль алийг сонирхож байна | 22% |
| Хараахан шийдээгүй байна | 2% |
| Хуучин сууц | 1% |

# ХУДАЛДАН АВАХ ЧАДВАРААР БАТАЛГААЖСАН ОРОН СУУЦНЫ ЭРЭЛТ - ТАХ

## *** ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН СОНИРХОЖ БУЙ ҮНЭ ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ***

Төрийн албан хаагчдын орон сууц худалдаж авахыг сонирхож байгаа м.кв-ын дундаж үнэ 1.2 сая төгрөг байна. Дээд үнийн дундаж 1.36 сая төгрөг, хамгийн доод үнийн дундаж 1.0 сая төгрөг байна. Худалдан авах чадвараар баталгаажсан албан хаагчдын 81% нь ипотекийн зээлээр, 10% нь 100 бэлнээр өөрийн хөрөнгөөр худалдаж авах сонирхолтой байна.

Худалдан авахаар сонирхож буй м.кв-ын үнэ, ДУНДАЖ ₮-өөр

1м2

| | |
|---|---|
| Дээд үнэ | 1,364,594₮ |
| **Дундаж үнэ** | **1,202,528₮** |
| Доод үнэ | 1,040,463₮ |

Худалдан авахаар сонирхож буй байрны нийт үнэ, ДУНДАЖ ₮-өөр

**75.8 сая.₮**



ТӨЛБӨР ТӨЛӨХ ХЭЛБЭР

| **Төлбөр төлөх** | **Хувь** |
|---|---|
| Ипотекийн зээлийн нөхцөлийг хангасан | 81% |
| 100 хувь бэлэн өөрсдийн хөрөнгөөр худалдаж авна | 10% |
| Газраа чөлөөлөн байраар солино *(бүгд 700 м.кв болон түүнээс дээш газартай)* | 5% |
| Бартер | 3% |
| Барилга баригдах хугацаанд хуваарийн дагуу бэлнээр | 1% |
| Хуучин орон сууцаа зарж солино | 1% |

# ХУДАЛДАН АВАХ ЧАДВАРААР БАТАЛГААЖСАН ОРОН СУУЦНЫ ЭРЭЛТ - ТАХ

ТЭНХЛЭГ ЗУУЧ
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ

15 ЖИЛ

## *** ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ОРОН СУУЦНЫ ЭРЭЛТ, ХУГАЦААГААР***

- Худалдан авах чадвараар баталгаажсан эрэлт бүхий 19201 төрийн албан хаагчдын 77% /14,899/ нь ойрын 2 жилийн дотор буюу 2018 болон 2019 онд орон сууц худалдан авах төлөвлөгөөтэй байна.

### ХЭДЭН ОНД ОРОН СУУЦТАЙ БОЛОХ ХЭРЭГЦЭЭ БАЙНА ВЭ?

| **2018 он** | **2019 он** | **2020 он** | **2021 он** | **2022 он** |
|---|---|---|---|---|
| **20.8%** | **26.4%** | **25.5%** | **15.4%** | **11.9%** |
| **/3,606 АХ/** | **/4,570 АХ/** | **/4,412 АХ/** | **/2,678 АХ/** | **/2,014АХ/** |

Орон сууц худалдан авах эрэлттэй байгаа өрхийн 52% нь буюу 8,982 албан хаагч ойрын 2 жилд худалдана авах хэрэгцээ байна.

# ТҮРЭЭСИЙН ОРОН СУУЦНЫ ХЭРЭГЦЭЭ - ТАХ

- Төрийн албан хаагчдын хувьд ойрын 3 жилийн дотор орон сууц **түрээслэх эрэлт 11% буюу 20,295 ТАХ** байна. Үүнээс 2018 онд түрээслэх эрэлт 80% /16,236/, 2019 онд 14% /2,842/, 2020 онд 6% /1,217/ байна.
- Орон сууц түрээслэх сонирхолтой байгаа өрхийн 70% буюу 14,206 албан хаагчид өөрийн өмчлөлийн сууцгүй шалтгаанаар орон сууц түрээслэх хэрэгцээ үүсэж байна.

**ТАНАЙ ӨРХӨД ОЙРЫН 3 ЖИЛИЙН ХУГАЦААНД ТҮРЭЭСИЙН ОРОН СУУЦНЫ ХЭРЭГЦЭЭ БАЙГАА ЮУ?**




**Улаанбаатар Хот /15,242 АХ/ 75%**

**Орон нутаг /5,053 АХ/ 25%**

Ямар шалтгаанаар орон сууц түрээслэн амьдрах сонирхолтой байгаа вэ?




**Одоогийн сууцны эзэмшлийн хэлбэр**

- Одоогийн сууцаа түрээслэж амьдардаг – 53%
- Төлбөргүйгээр бусдын сууцанд амьдардаг– 16%
- Хувийн өмчийн хашаа байшин – 15%
- Хувийн өмч, зээлийн барьцаанд байдаг– 11%

# ТҮРЭЭСИЙН ОРОН СУУЦНЫ ХЭРЭГЦЭЭ - ТАХ

- Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдыг нийгмийн бусад бүлэгт давхар харьяалагддаг эсэхийг судлахад нийт түрээсийн орон сууц сонирхож буй өрхийн 53% нь буюу 10,756 албан хаагч залуу гэр бүл бүлэгт, 6% нь буюу 1,217 албан хаагч өрх толгойлсон эцэг эх бүлэгт, 5% буюу 1,014 албан хаагч хөгжлийн бэрхшээлтэй, 2% буюу 405 өрх 4 болон түүнээс дээш хүүхэдтэй өрх бүлэгт ангилагдаж байна.



# ТҮРЭЭСИЙН ОРОН СУУЦНЫ ХЭРЭГЦЭЭ - ТАХ

ХААНА ЯМАР БАЙРШИЛД ТҮРЭЭСЛЭН АМЬДРАХ СОНИРХОЛТОЙ БАЙНА ВЭ?




- Түрээс орон сууц сонирхож байгаа төрийн албан хаагчдын 37% буюу 7,570 албан хаагч БЗД-т, 30.1% буюу 6,108 албан хаагч БГД-т сонирхож байна. Багахангай дүүрэгт 608 албан хаагч, Багануур дүүрэгт 162 орчим албан хаагч орон сууц түрээслэх эрэлттэй байна. Харин орон нутгийн албан хаагчдын хувьд өөрсдийн амьдарч буй аймагтаа бус, Улаанбаатар хотод түрээслэн амьдрах сонирхолтой байна.

# ТҮРЭЭСИЙН ОРОН СУУЦНЫ ХЭРЭГЦЭЭ - ТАХ

Түрээсийн орон сууц сонирхож буй төрийн албан хаагчид дунджаар 44.5 м.кв орон сууц түрээслэх сонирхолтой байна. 50-70 м.кв хэмжээтэйг 35.6%, 30-50 м.кв хэмжээтэй сууцыг 44% нь сонирхож түрээслэх эрэлттэй байна. Сарын түрээсийн үнийг дунджаар 286 мянган төгрөг байхаар төсөөлж байна.

Хэдэн м.кв сууц түрээслэхээр сонирхож байгаа вэ? **44.5** м.кв




Түрээсийн үнийн дүн хэдэн төг байхаар сонирхож байна вэ? **286,130 ₮**







Энэ мөнгөн дүнгээр түрээсийн барьцаа төлбөр урьдчилж 3 сараар төлөх боломжтой юу?




Эдгээр боломжгүй өрхийн сарын дундаж орлого **874,345 ₮**

## ОРОН СУУЦ ТҮРЭЭСЛЭХЭЭР СОНИРХОЖ БУЙ ТАХ-ЫН БУСАД НӨХЦЛҮҮД

Түрээсээ ямар хугацаагаар төлөх боломжтой вэ?




Байр түрээслэхэд ямар нөхцөл, шаардлагыг хангасан байх ёстой вэ?




### ТҮРЭЭСЛЭХ ХУГАЦАА

| Хугацаа | Хариулт |
|---|---|
| 1 жил дотор | 19% |
| 1-2 жил | 22% |
| 2-3 жил | 13% |
| 3-4 жил | 8% |
| 4-5 жил | 38% |

### ТҮРЭЭСЛЭХ ЯВЦДАА ӨӨРИЙН ӨМЧ БОЛГОХ СОНИРХОЛ

| Хугацаа | Хариулт |
|---|---|
| Тийм | 91% |
| Үгүй | 5% |
| Хэлж мэдэхгүй байна | 4% |

- Түрээсийн төлбөрийг сар сард нь өгөх байдлаар байх нь хамгийн зөв гэж 84.6% нь үзэж байна.
- Мөн түрээслэх сонирхолтой албан хаагчдын 91% нь түрээслэх орон сууц нь явцын дунд өөрийн эзэмшилд очих байдлаар шийдвэл илүү их таатай байхаар байна.

# ӨРХИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА- ТАХ

- Төрийн албан хаагчдын өрхийн сарын дундаж орлого 1,069,863 төгрөг байна.

## ОРЛОГО, ӨРХИЙН ЭД ХӨРӨНГӨ

### УЛААНБААТАР ХОТ

Өрхийн сарын ДУНДАЖ ОРЛОГО **1,163,758₮**

ХУРИМТЛАЛ БАЙГАА ЭСЭХ




Улаанбаатар хотын албан хаагчдын **64%** буюу **60435** албан хаагч ямар нэгэн хуримтлалгүй байна.

### ХӨДӨӨ, ОРОН НУТАГ

Өрхийн сарын ДУНДАЖ ОРЛОГО **978,484₮**

ХУРИМТЛАЛ БАЙГАА ЭСЭХ




Хөдөө орон нутгийн албан хаагчдын **71%** буюу **61422** албан хаагч ямар нэгэн хуримтлалгүй байна.

# ӨРХИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА- ТАХ

## ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Тийм, зээлтэй **85**%
*/158724 АХ/*

**15**% Үгүй, зээлгүй
*/27489 АХ/*

Цалингийн зээл




Тэтгэврийн зээл




Орон сууц, ҮХХ-ийн зээл




Автомашины зээл




Сургалтын төлбөрийн зээл




Бизнесийн зээл




Хэрэглээний зээл




Хадгаламж барьцаалсан зээл




Бусад зээл



- Улаанбаатар хотын хэмжээнд 2017 оны 01 сарын 1-ний өдрийн байдлаар 380,828 өрх амьдарч байгаа бөгөөд, тус оны байдлаар инженерийн дэд бүтэц бүхий орон сууцанд 164,791 өрх амьдарч байгаа нь нийт өрхийн 43 хувийг эзэлж байна. Гэр хороололд нийт өрхийн 57 хувь буюу 216,037 өрх амьдарч байна.
- Нийт өрхийн 24,6% буюу 94,712 өрх Баянзүрх дүүрэгт амьдарч байна. Улаанбаатар хотын хэмжээнд нийт 332,475 өрхөд шинээр инженерийн дэд бүтэц бүхий орон сууц, АОС-Хаус, уламжлалт аргаар шийдсэн хашаа байшин худалдан авах инженерийн дэд бүтэц бүхий орон сууц түрээслэх, дэд бүтэц бүхий хувийн сууц барих хэрэгцээ байна.
- Инженерийн дэд бүтэц бүхийн нийтийн орон сууц худалдан авах сонирхолтой нийт 216,913 өрх байгаа бөгөөд, эдгээр өрхүүдийн 38 хувь буюу 82,619 өрх нь 2019 онд сууцаа худалдаж авах хэрэгцээ байна. Харин цаашлаад 2020 онд нийт хэрэгцээтэй өрхийн 32 хувь буюу 69,433 өрхөд орон сууц хэрэгцээтэй байна.
- Инженерийн дэд бүтэц бүхий орон сууц худалдан авах нийт хэрэгцээтэй өрхүүдийн 71,798 өрх нь тодорхой хэмжээгээр урьдчилгаа төлбөр төлж, ипотекийн зээлд хамрагдах хүсэлтэй байгаа бөгөөд, энэхүү зээлийн урьдчилгаа төлбөр болох 30 хувийг, 26,193 өрх нь одооноос хуримтлуулж эхлэх төлөвлөгөөтэй байна.
- Улаанбаатар хотын хэмжээнд өрхүүдийн орон сууц худалдан авах, орон сууц түрээслэх эрэлтийг худалдан авах чадвараар тогтоон гаргахад хэрэгцээтэй байгаа нийт өрхийн 10,6% буюу 35,497 өрх нь худалдан авах чадвартай бөгөөд орон сууц худалдан авах эрэлттэй байна. Харин орон сууц худалдан авах чадваргүй 181,416 өрх байгаа ба эдгээр өрх нь санхүүгийн хувьд боломжгүй, чадваргүй ч худалдан авах хүсэл, сонирхол байна. Инженерийн дэд бүтэц бүхий сууц худалдан авах чадвартай өрхүүд дунджаар 2 өрөө, 41-60м2 талбайтай, бүрэн цутгамал хийцлэлтэй байрыг Хан-Уул дүүрэгт худалдан авах хэрэгцээтэй байна.
- Худалдан авах чадвартай нийт өрхийн 1 сарын орлого дунджаар 1,554,325 төгрөг байгаа бол, худалдан авах чадваргүй өрхүүдийн дундаж орлого 998,667 төгрөг байна. Худалдан авах чадвартай иргэдийн 34 хувь нь ямар нэг зээлтэй бол, чадваргүй иргэдийн 53 хувь нь ямар нэг зээлтэй байна.

- Ирэх 5 жилийн хугацаанд буюу 2022 он хүртэл амины орон сууц худалдан авах сонирхолтой нийт 21,505 өрх байгаа бөгөөд эдгээр өрхүүдийн 32 хувь буюу 6,777 өрх нь дэд бүтэц бүхий энэхүү амины орон сууцаа 2018 онд худалдан авах төлөвлөгөөтэй байна.
- Худалдан авах чадвараар баталгаажсан нийт 4,446 өрх байгаа бөгөөд эдгээр өрхийн орлого нь 3 сая ба түүнээс дээш төгрөг, өрх тодорхой хэмжээгээр хуримтлалтай байгаа юм. Амины орон сууц худалдан авах төлөвлөгөөтэй байгаа нийт өрхийн 28,6 хувь нь Баянзүрх дүүрэг, тэр дундаа Хужирбулан, Дүнжингарав худалдааны төвийн ойр орчимд, Улиастай, Эрдэнэтолгойд худалдаж авах сонирхолтой байна. Худалдан авах амины орон сууцаа 1м2-ыг нь 1,410,000 төгрөгөөр худалдаж авахаар төлөвлөж байна.
- Улаанбаатар хотын хэмжээнд ирэх 3 жилийн хугацаанд инженерийн дэд бүтэц бүхий орон сууц түрээслэх 44,747 өрх байгаа бөгөөд энэ нь нийт хэрэгцээтэй өрхийн 12 хувийг эзэлж байна. Түрээсийн орон сууц хэрэгцээтэй өрхийн 59,5 хувь буюу 26,652 өрх нь гэр хороололд амьдардаг бол үлдсэн 37,3 хувь буюу 16,717 өрх нь инженерийн дэд бүтэц бүхий орон сууцанд амьдарч байна.
- Эдгээр өрхүүдийн хувьд орон сууц түрээслэх гол шалтгаан нь 1-рт гэр бүлийн хэрэгцээнд зориулж, 2-рт өөрийн өмчлөлийн сууцгүй тул, 3-рт амьдралын боломж тааруу гэсэн шалтгаантай байна. Түрээсийн орон сууц хэрэгцээтэй байгаа нийт өрхийн 33,9 хувь нь 35 хүртэлхи насны “залуу гэр бүл” байна. Эдгээр өрхийн 15,653 өрх нь Баянзүрх дүүрэгт түрээслэх сонирхолтой байна.
- Дунджаар 31-50м2 талбайтай, 2 өрөө байрыг 4-5 жилийн хугацаатай түрээслэх ба энэхүү түрээсийн орон сууцаа түрээслэх явцдаа өөрийн өмч болгох сонирхолтой байна.
- Улаанбаатар хотод нийтдээ инженерийн дэд бүтэц бүхий орон сууц түрээслэн амьдардаг нийт 31,402 өрх байгаа бөгөөд эдгээр өрхүүдийн 76,2 хувь буюу 23,948 өрхөд инженерийн дэд бүтэц бүхий орон сууц худалдан авах хэрэгцээ байна.

# ДҮГНЭЛТ

- Улаанбаатар хотын хэмжээнд ирэх 3 жилийн хугацаанд дэд бүтэц бүхий хувийн сууц барих хэрэгцээтэй нийт 73,336 өрх байгаа бөгөөд эдгээр өрхийн 40 хувь буюу 28,928 өрх нь энэхүү сууцаа 2020 онд барих төлөвлөгөөтэй байна.
- Дэд бүтэц бүхий хувийн сууц барих төлөвлөгөөтэй нийт өрхийн 26,7 хувь буюу 15,863 өрх нь инженерийн дэд бүтэц бүхий орон сууцанд амьдарч байна.
- Баянзүрх дүүрэгт сууцаа барих сонирхолтой 23,817 өрх байна.
- Нийт өрхүүд 73,6м2 талбайтай, 3 болон 4 өрөө, сууцны нийт үнийн дүн 50,675,749 төгрөг байхаар төлөвлөж байна. Энэхүү сууцаа 36 хувь нь, 100 хувь өөрсдийн хөрөнгөөр барих бол дараагаар нь 28,8 хувь нь арилжааны банкнаас зээл авч барих төлөвлөгөөтэй байна. Мөн "амины орон сууцны зээл"-д хамрагдах хүсэлтэй иргэд байгаа юм.
- Өөрийн өмчлөлийн газартай нийт 98,633 өрх байгаа бөгөөд эдгээр өрхүүдээс; Ирэх 3 жилийн хугацаанд өөрсдийн эзэмшлийн хашаанд дэд бүтэц шийдэж, шугам сүлжээг оруулж ирвэл амьдрах сууцаа өөрчлөх эсэх талаар тодруулахад 49 хувь нь "шинэ байшин" барих сонирхолтой байгаа ба энэхүү сууцаа 44,4 хувь нь зээлээр барих хүсэлтэй байна.
- Монгол улсын хэмжээнд 2017 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 192,475 төрийн албан хаагч ажиллаж байна. Үүнээс 49% буюу 94977 төрийн албан хаагч Улаанбаатар хотод үлдсэн 51% нь буюу 97498 төрийн албан хаагч бусад 21 аймагт ажиллаж байна.
- Улсын хэмжээнд төрийн албан хаагчдын орон сууц худалдан авах, орон сууц түрээслэх болон хувийн сууц барих эрэлтийг худалдан авах чадвараар тогтоон гаргахад нийт төрийн албан хаагчдын 29% буюу 45 мянган албан хаагч худалдан авах чадвартай бөгөөд орон сууц худалдан авах эрэлттэй байна.
- Үүнээс 19 мянган албан хаагч буюу 42% нь 2018 онд, 16 мянган албан хаагч буюу 35% нь 2019 онд худалдан авах сонирхолтой байна.

REAL ESTATE
REAL SOLUTIONS

# УБ ХОТЫН ОРОН СУУЦНЫ НИЙЛҮҮЛЭЛТИЙН СУДАЛГАА



Улаанбаатар хотын хэмжээнд амины болон нийтийн орон сууцны 427 төслийн 62,339 айлын орон сууцны төсөл хэрэгжиж байна. Эдгээрийн 59,426 айл нь нийтийн орон сууц, 2,913 айл нь амины орон сууцны төсөл байна.



**62,339** айлын
НИЙТИЙН болон АМИНЫ
орон сууцны **427** төсөл

**НИЙТИЙН ОРОН СУУЦ**



**59,426 айлын**
**334 төсөл**

**АМИНЫ ОРОН СУУЦ**



**2913 айлын 93 төсөл**

# ШИНЭ ОРОН СУУЦНЫ ЗАХ ЗЭЭЛ, АШИГЛАЛТАНД ОРСОН БАЙДАЛ, БОРЛУУЛАЛТ

**59,426**
**Нийтийн орон сууцны төсөл хэрэгжиж байна**

**Ашиглалтанд орсон**
**22,489**
айлын орон сууц

**Ашиглалтанд ороогүй**
**36,937**
айлын орон сууц

ЭДГЭЭРЭЭС БОРЛОГДООГҮЙ

**5822**

**32,692**

**НИЙТ ОРОН СУУЦНЫ НИЙЛҮҮЛЭЛТ 38,514**

# ШИНЭ ОРОН СУУЦНЫ НИЙЛҮҮЛЭЛТ, ОНООР

| | 2018 он | 2019 он | 2020 он | Нийт |
|---|---|---|---|---|
| Төлөвлөсөн | 20,207 | 15,586 | 1,144 | **36,937** |
| Тооцоолсон | 12,343 | 10,113 | 14,481 | **36,937** |
| Борлогдсон | 3,396 | 849 | | **4,245** |
| Борлогдоогүй нийлүүлэлт | 8,947 | 9,264 | 14,481 | **32,692** |
| Ашиглалтанд орсон борлогдоогүй | 5822 | - | - | - |
| Нийт | 14,769 | 9,264 | 14,481 | 38,514 |

**Тайлбар:**

**ТӨЛӨВЛӨСӨН** - Төсөл хэрэгжүүлэгчийн ашиглалтанд оруулахаар төлөвлөсөн хугацаа

**ТООЦООЛСОН** – Судлаачийн тооцоолсон хугацаа

**14,769 Айл**

**2018 он**

**9,264 Айл**

**2019 он**

**14,481 Айл**

**2020 он**

ИРЭХ 3 ЖИЛИЙН ХУГАЦААНД 38,514 АЙЛЫН ОРОН СУУЦ НИЙЛҮҮЛЭГДЭНЭ

# ШИНЭ ОРОН СУУЦНЫ ТОО, гүйцэтгэлээр

**Ойрын 3 жилд ашиглалтанд орох 36,937 айлын орон сууц, гүйцэтгэлээр**




2018 он




2019 он




2020 он




2018 онд ашиглалтанд орох орон сууцнаас 67% буюу 8,357 айлын орон сууц нь 51-с дээш хувийн гүйцэтгэлтэй байна.

# НИЙТ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ТОО, БАЙРШЛААР

**НИЙТ ОРОН СУУЦНЫ НИЙЛҮҮЛЭЛТ 38,514**



# НИЙТ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ТОО, ЗЭРЭГЛЭЛЭЭР

**НИЙТ ОРОН СУУЦНЫ НИЙЛҮҮЛЭЛТ 38,514**




- ✓ Байршил
- ✓ Дотор засал, барилгын хийц, чанар
- ✓ Хэрэгжүүлэгч компанийн нэр хүнд, туршлага
- ✓ Хотхоны ерөнхий төлөвлөлт
- ✓ Хотхоны талбайн хэмжээ
- ✓ Орон сууцны талбайн хэмжээ
- ✓ Орон сууцны болон зогсоолын тооны харьцаа
- ✓ Талбайн дундаж хэмжээ
- ✓ Проперти менежмент
- ✓ Үнэ

гэх мэт гол шалгууруудад үндэслэн зэрэглэлд ангилж үзэхэд 44% нь дундаж, 37% нь стандарт, 10% нь бизнес, 2% нь өндөр зэрэглэлд хамрагдаж байгаа юм.

# НИЙТ ОРОН СУУЦНЫ НИЙЛҮҮЛЭЛТ
# 38,514

## Нийт нийлүүлэлт, талбайн хэмжээгээр




## Нийт нийлүүлэлт, өрөөний тоогоор



# НИЙТ НИЙЛҮҮЛЭЛТИЙН ТОО, ЗЭРЭГЛЭЛ, ТАЛБАЙН ХЭМЖЭЭГЭЭР

**НИЙТ ОРОН СУУЦНЫ НИЙЛҮҮЛЭЛТ 38,514**




Дээрхи графикаас харахад стандарт зэрэглэлийн орон сууцны талбай 150м2-с дээш, өндөр зэрэглэлийн орон сууцны хувьд 60м2-с доош талбай төлөвлөгдөөгүй байна.

# АШИГЛАЛТАНД ОРСОН, БОРЛУУЛАГДААГҮЙ ОРОН СУУЦНЫ БАЙРШИЛ

**АШИГЛАЛТАНД ОРСОН БОРЛОГДООГҮЙ 5822**



# БОРЛОГДООГҮЙ ОРОН СУУЦНЫ ТОО, ТАЛБАЙН ХЭМЖЭЭГЭЭР

ТЭНХЛЭГ ЗУУЧ
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ

**АШИГЛАЛТАНД ОРСОН БОРЛОГДООГҮЙ**
**5822**

- **80м2-с доош** **4622**
- **80м2-с дээш** **1200**

**АШИГЛАЛТАНД ОРООГҮЙ БОРЛОГДООГҮЙ**
**32692**

- **80м2-с доош** **24890**
- **80м2-с дээш** **7802**

**АШИГЛАЛТАНД ОРООГҮЙ БОРЛОГДООГҮЙ /БОРЛУУЛАЛТ ХИЙГДЭЖ БАЙГАА/**
**5721**

- **80м2-с доош** **4342**
- **80м2-с дээш** **1379**

Зах зээл дээр худалдахаар захиалга авч буй 32,455 айлын орон сууцнаас борлогдоогүй **11,543** айлын орон сууц байгаа ба эдгээрийг талбайн хэмжээгээр ангилж үзэхэд 78% буюу **8,964** айлын орон сууц нь **80м2-с доош** талбайтай байна.

Харин ирэх 3 жилийн нийт нийлүүлэлт **38,514** айлын орон сууцнаас тооцвол **80м2-с доош талбайтай 29,512** айлын орон сууц байна.

Улаанбаатар хотод баригдахаар төлөвлөгдсөн **217** орон сууцны төсөл байгаа ба тэдгээрийн **93%** нь нийтийн орон сууцны, **7%** нь амины орон сууцны төсөл байна. Эдгээр төслүүдийн хувьд ямар нэгэн барилгын ажил эхлүүлээгүй, ажил явагдаагүй байгаа учир нийлүүлэгдэх айлын тоо, хугацаа зэргийг одоогоор тодорхойлох боломжгүй байна.

## төлөвлөгдөж буй 217 төсөл




Баригдахаар төлөвлөгдсөн 217 төслөөс байршлын хувьд хамгийн их нь БЗД, БГД, ХУД-үүдэд төлөвлөгдсөн байна.

## Захиалга авч байгаад барилгын ажил түр зогссон 30 төсөл




2018 оны 3-р сарын байдлаар УБ хотод хэрэгжиж буй нийт төслөөс барилгын ажил нь түр зогссон 30 төсөл байгаа ба үүнээс ХУД-т хамгийн олон буюу 13 төсөл зогссон байна.

Зогссон хугацааны хувьд эдгээр төслүүд нь 1 жилээс дээш хугацаагаар зогссон төслүүд байна.

REAL ESTATE
REAL SOLUTIONS

15 ЖИЛ

ТЭНХЛЭГ ЗУУЧ
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ

# ГЭР ХОРООЛЛЫН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ

# ГЭР ХОРООЛЛЫН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд 23 компани эхний ээлжийн 10407 айлын барилгын ажил эхэлсэн ба түүнээс 5197 нь ашиглалтанд орсон байна.

| Дүүрэг | Хэрэгжиж байгаа | | Захиалга авч байгаа | |
|---|---|---|---|---|
| | Төсөл хэрэгжүүлэгч | Айлын тоо | Төсөл хэрэгжүүлэгч | Айлын тоо |
| Чингэлтэй | 5 | 454 | | - |
| Сүхбаатар | 4 | 3512 | 2 | 192 |
| Баянгол | 2 | 836 | 1 | 112 |
| Баянзүрх | 9 | 4666 | 2 | 848 |
| Сонгинохайрхан | 2 | 843 | 2 | 451 |
| Хан-Уул | 1 | 96 | | - |
| **Нийт** | **23** | **10407** | **7** | **1603** |

# ГЭР ХОРООЛЛЫН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТӨСЛҮҮДИЙН ҮНЭ, БОРЛУУЛАЛТ

ГХДТ-ийн төслийн хүрээнд хэрэгжиж буй дараах 7 төсөл дээр захиалга авч буй 1603 айлын орон сууцны 37,6% буюу 603 айлын орон сууц нь борлогдоогүй байна. Үүнээс 406 айлын орон сууц ашиглалтанд орсон, 197 нь ашиглалтанд ороогүй байна.

**Захиалга авч буй төслүүдийн дундаж үнэ**




**ГХДТ-ийн төслүүдийн борлуулалт, талбайн хэмжээгээр**




**ГХДТ-ийн төслүүдийн борлуулалт, өрөөний тоогоор**



# ГХДТ-ИЙН ТӨСЛҮҮДИЙН БАЙРШИЛ, Сүхбаатар дүүрэг





# ГХДТ-ИЙН ТӨСЛҮҮДИЙН БАЙРШИЛ, Чингэлтэй дүүрэг




**Асар өргөө ХХК**
**Шинэ хайлааст хотхон**
**60 айл**

**Буурал сутай ХХК**
**Хайлааст хотхон**
**500 айл**

**Бармон ХХК**
**Шинэчлэл хороолол**
**3800 айл**

# ГХДТ-ИЙН ТӨСЛҮҮДИЙН БАЙРШИЛ, Баянзүрх дүүрэг

ТЭНХЛЭГ ЗУУЧ
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ



# ГХДТ-ИЙН ТӨСЛҮҮДИЙН БАЙРШИЛ, Сонгинохайрхан дүүрэг



# ГХДТ-ИЙН ТӨСЛҮҮДИЙН БАЙРШИЛ, Баянгол дүүрэг



REAL ESTATE
REAL SOLUTIONS

15 ЖИЛ

ТЭНХЛЭГ ЗУУЧ
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ

# АМИНЫ ОРОН СУУЦНЫ НИЙЛҮҮЛЭЛТ

Улаанбаатар хотын хэмжээнд амины орон сууцны 93 төслийн 2,913 айлын төсөл хэрэгжиж байгаа бөгөөд эдгээрээс 47 төслийн 1148 айлын амины орон сууц ашиглалтанд орж, 46 төслийн 1765 айлын амины орон сууц ашиглалтанд ороогүй байна.

**2913 айлын 93 төсөл**

**Ашиглалтанд орсон**
**47 төсөл 1,148 айл**

**47 төслийн 1148 айл**

**Ашиглалтанд ороогүй**
**46 төсөл 1,765 айл**

| | |
|---|---|
| **Захиалга авч байгаа** | **10 төслийн 451 айл** |
| **Захиалга эхлээгүй** | **19 төслийн 261 айл** |
| **Захиалга зогссон** | **17 төслийн 1053 айл** |

# АМИНЫ ОРОН СУУЦНЫ ТОО, БАЙРШИЛААР

**93**
**төсөл**
**2,913**
**айлын амины орон сууцны төсөл хэрэгжиж байна**



# АМИНЫ ОРОН СУУЦНЫ ТОО



**Ашиглалтанд орсон байдал**

**АШИГЛАЛТАНД ОРСОН** — **1040**

**АШИГЛАЛТАНД ОРООГҮЙ** — **1873**

Ашиглалтанд орох хугацаагаар нь авч үзвэл 36% нь ашиглалтанд орсон байна.

**Загвар төрөл**

ХАУС 56%

ТАУНХАУС 44%

**Инженерийн ХАНГАМЖ-д холбогдсон байдал**



## ШИНЭ ОРОН СУУЦНЫ ЗАХ ЗЭЭЛ, АШИГЛАЛТАНД ОРСОН БАЙДАЛ, БОРЛУУЛАЛТ

**Инженерийн бүрэн хангамжтай 413**

**Ашиглалтанд орсон 83** айлын орон сууц

**Ашиглалтанд ороогүй 330** айлын орон сууц

ЭДГЭЭРЭЭС БОРЛОГДООГҮЙ

**26**

**259**

**НИЙТ АМИНЫ ОРОН СУУЦНЫ НИЙЛҮҮЛЭЛТ 285 БҮГД 2018 ОНД АШИГЛАЛТАНД ОРНО**

# АМИНЫ ОРОН СУУЦНЫ ТОО, ЗЭРЭГЛЭЛЭЭР

**Нийт хэрэгжиж буй**
**2,913 айл**




**Инженерийн бүрэн хангамжтай**
**413 айл**




Хэрэгжиж буй нийт амины орон сууцны төслийн 60% нь стандарт зэрэглэлд хамрагдаж байгаа ба инженерийн бүрэн хангамжтай 413 амины орон сууц нийт төслийн 14%-ийг эзэлж байна. Энэхүү 413 сууцны 62%-ийг стандарт, 26%-ийг өндөр зэрэглэлийн хаус эзэлж байна.

# НИЙТ АМИНЫ ОРОН СУУЦНЫ НИЙЛҮҮЛЭЛТ 285 БҮГД 2018 ОНД АШИГЛАЛТАНД ОРНО

### Талбайн хэмжээгээр




### Өрөөний тоогоор



REAL ESTATE
REAL SOLUTIONS

# УБ ХОТЫН ОРОН СУУЦНЫ ҮНИЙН СУДАЛГАА

15 ЖИЛ

ТЭНХЛЭГ ЗУУЧ
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ

# ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС /2018.03/

Тэнхлэг Зууч компани 2013 оны 10 сараас эхлэн Монгол банкны захиалгаар Улаанбаатар хотын Орон сууцны үнийн индексийг сар болгон тооцож байгаа ба тухайн сард Улаанбаатар хотод зах зээлд нийлүүлэгдсэн шинэ болон хуучин нийлсэн 5000 орчим орон сууцны мэдээллийг хамруулдаг.

ЕРӨНХИЙ ИНДЕКС **1.025**
ЖИЛИЙН ӨӨРЧЛӨЛТ ↑ **1.49%**
САРЫН ӨӨРЧЛӨЛТ ↑ **0.78%**

ХУУЧИН ОРОН СУУЦ **0.93**
ЖИЛИЙН ӨӨРЧЛӨЛТ ↑ **1.29%**
САРЫН ӨӨРЧЛӨЛТ ↑ **2.51%**

ШИНЭ ОРОН СУУЦ **1.206**
ЖИЛИЙН ӨӨРЧЛӨЛТ **2.52%**
САРЫН ӨӨРЧЛӨЛТ **4.51%**



# ШИНЭ ОРОН СУУЦНЫ ҮНЭ, 1м.кв-₮ -Оноор



# ШИНЭ болон ХУУЧИН ОРОН СУУЦНЫ ҮНЭ, 1м.кв-сая.₮-сараар



# ШИНЭ ОРОН СУУЦНЫ ДУНДАЖ ҮНЭ, 1м.кв-сая.₮-Зэрэглэлээр



# ШИНЭ ОРОН СУУЦНЫ ДУНДАЖ ҮНЭ /ДҮҮРГЭЭР/

Шинэ орон сууцны дундаж үнэ 2018 оны 3-р сард өмнөх сараас 1,45%-иар, өнгөрсөн оны мөн үеэс 10,7%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Энэхүү өсөлтөнд шинээр нэмэгдсэн төслүүдийн зарим нь нэлээд өндөр үнэтэй төслүүд байсантай холбоотой юм.

ТӨВИЙН 6 ДҮҮРГИЙН ЗАХИАЛГЫН ДУНДАЖ ҮНЭ

**2,424,688 1м2-₮**

АЛСЛАГДСАН ДҮҮРГҮҮДИЙН ЗАХИАЛГЫН ДУНДАЖ ҮНЭ

**1,288,472 1м2-₮**



# АШИГЛАЛТАНД ОРСОН ШИНЭ ОРОН СУУЦНЫ ҮНЭ, БОРЛУУЛАЛТ

Ашиглалтанд орсон 22,489 айлын орон сууцны 43% нь 1,5-2,0 сая төгрөгийн үнэтэй орон сууц байгаа бол 29% нь 2,0-2,5 сая төгрөгийн үнэтэй орон сууц эзэлж байна. Харин хамгийн бага буюу 7% нь 1,0-1,5 сая төгрөгийн үнэтэй орон сууц байна.

**Захиалгын дундаж үнэ /1м.кв-₮/, интервалиар**




**Хамгийн хямд үнэтэй орон сууц:**

- Жуков хотхон
- Суварга хотхон
- Шинэ налайх хорооолол гэх мэт

**Хамгийн хямд үнэтэй орон сууц:**

- Choijin suites
- Jardin residence
- Бэлла виста хотхон гэх мэт

**Борлуулалтын явц, интервалиар**




Борлуулалтын байдлыг интервалиар харвал 82% нь 51%-иас дээш борлуулалттай байгаа бол 18% нь буюу 3871 айлын орон сууц 50%-иас доош борлуулалттай байгаа юм.

# ХАУС, ТАУНХАУСНЫ ДУНДАЖ ҮНЭ, 1м2-₮




Хаусны дундаж үнэ, 2018 оны 3-р сар




Улаанбаатар хотын хэмжээнд 2018 оны 3-р сарын байдлаар хаусны дундаж үнэ 2,109,676 мянган төгрөг болж өмнөх сараас 0,39 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

# ХАУС, ТАУНХАУСНЫ ДУНДАЖ ҮНЭ, 1м2-₮

Дундаж үнийг дүүргээр ангилж харвал хамгийн өндөр нь БЗД-т 1м2 үнэ 2,991,440 төгрөгөөр захиалга авч байна. Харин хамгийн хямд үнэтэй хаусны төсөл Багануур дүүрэгт байна.

ХАУСНЫ ДУНДАЖ ҮНЭ, ДҮҮРГЭЭР /1М.КВ-САЯ.₮/




ХАУС, ТАУНХАУСНЫ ҮНЭ, ЗЭРЭГЛЭЛЭЭР



# ДҮГНЭЛТ

- Улаанбаатар хотын хэмжээнд 2017 оны байдлаар нийт **380,828** өрх амьдарч байгаагийн 43 хувь буюу **164,791** өрх нь нийтийн зориулалттай орон сууцанд амьдарч байна.
- Ирэх 3 жилийн хугацаанд 427 төслийн 62,339 айлын нийтийн болон амины орон сууц ашиглалтанд орохоор хэрэгжиж байгаа ба үүний 95% буюу 59,426 айлын орон сууц нь нийтийн орон сууц байна. Үүнээс **38,514** айлын орон сууц нийлүүлэгдэхээр харагдаж байна. Энэхүү нийлүүлэлтийг оноор тооцвол 2018 онд 14,769, 2019 онд 9,264, 2020 онд 14,481 орон сууц нийлүүлэгдэх нь ирэх 3 жилд нийлүүлэлтийн илүүдэлтэй байх төлөвтэй байна.
- Ашиглалтанд орсон, бэлэн **5822** айлын орон сууц зах зээл дээр худалдагдаж байна. Үүний 34% нь БЗД-т, 30,4% нь ХУД-т баригдсан байна.
- Мөн нийт нийлүүлэлтийн **37%** нь БЗД-т хэрэгжиж байгаа бол зэрэглэлийн хувьд **44%** нь дундаж, 37% нь стандарт зэрэглэлд хамрагдах сууцнууд байна.
- Талбайн сонголтын хувьд 41-60м2 талбайтай орон сууцны нийлүүлэлт хамгийн их буюу 14,526 /38%/ айлын орон сууц байна. Харин өрөөний тооны хувьд 2 өрөө 44%, 3 өрөө 30%-ийг эзэлж байгаа нь нийт нийлүүлэлтийн 28,746 нь 2 болон 3 өрөөний зохион байгуулалттай нийлүүлэгдэж байна.
- Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд 23 компани барилгын ажлаа эхлүүлсэн, 10407 айлын орон сууц барьж байгаа ба үүнээс 5197 нь ашиглалтанд орсон, 5210 айлын орон сууц ашиглалтанд ороогүй байна. Харин 7 төсөл 1603 айлын орон сууцанд борлуулалт хийж байна. Борлуулалт нь 37,6%-тай буюу 603 айлын орон сууц борлогдоогүй байна. Тооцоолол хийхэд ГХДТ-ийн нийт нийлүүлэлт ашиглалтанд орсон борлогдоогүй 406, ашиглалтанд ороогүй 5,193, нийт **5,599** байна. ГХДТ-ийн төслүүдийн дундаж үнэ 1м.кв нь 1,730,313 төгрөгийн үнэтэй байна.
- Улаанбаатар хотын 5 дүүрэгт амины орон сууцны 2913 айлын 93 төсөл хэрэгжиж байгаа ба эдгээрээс 413 нь буюу 14% нь инженерийн бүрэн хангамжтай сууцнууд байна. Үүнээс 83 хаус нь ашиглалтанд орсон, 330 нь ашиглалтанд ороогүй байна. Борлуулалтын хувьд инженерийн бүрэн хангамжтай 413 айлын сууцнаас 285 ш борлогдоогүй үлдсэн байна. Хаусны дундаж үнэ 1м2 нь 2,1 сая төгрөгийн үнэтэй байна.


15 ЖИЛ
ТЭНХЛЭГ ЗУУЧ
ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН КОМПАНИ
АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА
Чингэлтэй дүүрэг, 2 хороо, Их найман шарга төв, 3 давхар 301 тоот
info@tz.mn
11-33 22 33